

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

|   |                      |                     |            |
|---|----------------------|---------------------|------------|
| Ярилцлага өгөгчийн нэр                              | Мөнхтогоо            | Дугаар              | L271       |
| Оршин суугаа аймаг                                  | Төв аймаг            | Оршин суугаа сум    | Лүн сум    |
| Төрсөн газар  | Лүн сум              | Төрсөн он           | 1920       |
| Ажил мэргэжил                                       | Өндөрнастан          |                     |            |
| Лам байсан эсэх,<br>Шавилан сууж байсан сүм<br>хийд | Цагаан нуурын хурал  | Сүм хийдийн дугаар  | ТӨЛҮ 019   |
| Одоогийн сүм хийд                                   |                      | Сүм хийдийн дугаар  |            |
| Ярилцлага авсан он сар<br>өдөр                      | 2007 оны10-рсарын 20 | Ярилцлага авсан хүн | Д .Мөнхбат |

### Төв аймгийн Лүн сумын Цагаан нуурын хурал

Мөнхбат: Манай судалгааны баг Төв аймгийн Лүн сумын нутгаас судалгааны ажлаа үргэлжлүүлж байна.Тэгэхээр Лүн сумын 1-р багийн харъяат өндөр настан, эдүгээ нас сүүдэр 87 насыг зооглож байгаа Мөнхтогоо гуайтай дараах ярилцлагыг хийсэн юм аа. Тэгэхээр Мөнхтогоо гуай энэ Лүн сумын нутагт байсан Цагаан нуурын хуралд бага насандаа шавилан сууж байсан ийм өндөр настай буурал.Тэгэхээр бид нар Мөнхтогоо гуайгаас дараах асуултыг асууж хариулт авсан юм аа.За тэгэхээр энэ Лүн сумын 1-р багийн нутагт байх Цагаан нуурын хурлын тухай ат одоо багадаа сууж тэнд одоо Түвд ном бичиг заалгаж сууж байсан гэж байна.Тэгэхээр тэр хурал маань энэ хавьдаа хэр том хурал байсан юм, хичнээн ламтай байсан юм, байнгын ажиллагаатай байсан юм уу, цагийн хурал байсан юм уу энэ талаар ярилцлагаа эхлээ?

Мөнхтогоо: Том хурал байсан юм. Чи асуу л даа.

Мөнхбат. Хичнээн ламтай байсан юм бол?

Мөнхтогоо: Одоо нэг зуугаад шахуу ламтай байсан байх.Их л лам байсан. Байнга, өвөл зунгүй. Өвөл нь энэ урд хар чулуу гэж өвөлжөө байгаа юм Тэнд цагаан сарынхаа хурлыг хурж байсан юм.Тэнд хурахдаа гэр бариад, цагаан сараар золгож байсан юм. Энэ голд чинь хүн байхгүй, хөдөө гарчихсан.Жас руу ирж байсан. Малууд нь хөдөө, суур нь малууд нь энд хөдөө өвөлждөг.

Мөнхбат:Та ер нь хэдэн настайдаа тэнд сууж байсан бэ?

Мөнхтогоо: За хорь хүрээгүй байх аа.

Мөнхбат: Удсан уу, тэнд?

Мөнхтогоо: Өө 3, 4 жил шахуу гүйсэн.Энэ голын дэрсээр хөл нүцгэн, хөл хагарчихсан, харгана дээр гүйж байсан. Энэ цав манзны юм горьдоод л явна шүү дээ.Манз гэдэг нь цай шүү дээ.

Мөнхбат: Хурлын тэргүүн нь гэдэг юм уу, ловон лам нь ямар хүн байсан юм бол?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхтогоо: Чойжил лам гэж байсан юм. Манай ах байсан юм. Чойжилжав гэж. Хоёр лам байсан юм, одоо их Чойжил, бага Чойжил гэж.

Мөнхбат: Ер нь тэр зуугаад лам дотор шашны том мяндаг тушаалтай, цол хэргэмтэй лам нар хэр олон байсан юм бол оо?

Мөнхтогоо: Аа байсан байх, зөндөө байсан байх. Тэр болгоныг би мэдэхгүй. Байсан байх. Бид харахлээр л ухаан алдчихаж.

Мөнхбат: Ямар гол сахиус шүтээнтэй байсан юм бол?

Мөнхтогоо: За тэрийг бол мэдэхгүй.

Мөнхбат: Ямар ном уншиж байв?

Мөнхтогоо: Үгүй ээ, янз бүрийн л ном заалгаж байсан. Хүзүүнээсээ шоголтой ном уячихсан л явдаг байсан хүн дээ.

Мөнхбат: Хэдэн дугантай байсан юм бол?

Мөнхтогоо: Гурав шахуу дугантай байсан байх. Байшингууд л байсан даа.

Мөнхбат: Тойроод лам нарын гэр орон?

Мөнхтогоо: Аа тэр энэ голоор ч айлууд байсан. Тэндээ ч улсууд гэр оронтой байсан.

Мөнхбат: Жас хөрөнгийн хувьд ер нь ямархуу байсан юм бол, Цагаан нуурын хурал?

Мөнхтогоо: Жас ямар юм аа?

Мөнхбат: Жас хөрөнгө? Одоо мал хөрөнгө?

Мөнхтогоо: Өө мундаг. Ер нь ингээд ном мом айлтгахад чинь мал л өгдөг. Цаасан мөнгө ховор ч юм уу, би бага байсан сайн мэдэхгүй. Мал өгөхөөр чинь сүрэг малд аваачиж өгнө. Хэдэн бяруу гээд л аваачиж өгөхөөр ганц бяруу гээд л тэгж сүрэглүүлж байж байсан. Одоо нэгдэл шиг маллуулж, тэр болгоныг би хаанаас бүгдийг нь мэдэхэв дээ, бага байсан юм чинь.

Мөнхбат: Хурлын дэг жаяг гэж ярьдаг ш дээ, ая дан. Энэ хүрээ хийдүүд чинь өөр өөрсдийн тийм тогтсон ая дан гэж байдаг ш дээ. Тийм юмнаас энэ манай хурал чинь иймэрхүү ая дантай байсан гэж танд санаанд үлдсэн юм байх юм уу? Ая дан, одоо ном унших, уншлага хийх?

Мөнхтогоо: Өө тэр байсан байх. Гэсгүй энэ тэр гэж байгаа шүү дээ. Тэрийг чинь их дэгтэй хурдаг. Хоёр талд нь нэг их хадаг самбаа болчихсон тийм одоо миний муу таягархуу тийм хулс байдаг. Тэрүүгээр биднүүдийг нүддэг./ инээв /

Мөнхбат: Цам майдар талын зан үйл гарах уу, цам харайж майдар эргэх тийм шашны зан үйл хийх үү?

Мөнхтогоо: Аа мэдэхгүй. Үгүй байх. Сайн мэдэхгүй байна.

Мөнхбат: Энэ хэлмэгдүүлэлтийн үед эндээс хичнээн лам баригдаад явсан юм бол?

Мөнхтогоо: Аа мэдэхгүй, зөндөө л лам баригдаад явсан. Манай хоёр ах лам баригдаад явсан, аавын ах. Их Чойжил, бага Чойжил гэж хоёр ах лам баригдаад явсан.

Мөнхбат: Буцаж ирээгүй олон хүн бий юу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхтогоо: Буцаж ирээгүй юу, өө олон бий. Манай хоёр ах лам баригдаад явсан. Энд нэг хүн баригдаад хэлгүй болоод ирсэн. Тэгээд эндээ нас барсан. Энэ Ринчен гуайг хэлж байгаа юм.

Мөнхбат: Энэ лам нарыг 1937, 1938 оны үед барьж явчихаад хүрээ хийд эзгүйрчихээд энэ гурван дуган байгаад л байсан уу, эсвэл лам нарыг нь барьчихаад тэр дор нь шатаачихсан уу...?

Мөнхтогоо: Өө мэдэхгүй. Шатаасан барьсаныг мэдэхгүй.

Мөнхбат: Гурван дуган нь алга болчихсон уу?

Мөнхтогоо: Алга болчихсон, хаашаа алга болсныг яаж мэдэхэв?

Мөнхбат: Дөв тавиад оны нүүрийг үзээгүй юу?

Мөнхтогоо: Үгүй, тэр дороо л байхгүй болчихсон. Хумиад авчихсан юм уу, яаж мэдэхэв. Баахан тогоо л үлдсэн байсан. Тогоог нь хонины хүүхдүүд хага цохиод хаячихсан. Том том тогоо, манай энэ гэр шиг том тогоо...

Мөнхбат: За хоёулаа ингээд ярилцлагаа түр завсарлая.

### Цагаан толгойн хурал

Мөнхтогоо: Цагаан толгойн хурал гэж одоо байж байгаа тэр бор толгой дээр л байж байсан хурал байгаа юм. Тэнд нэг хамаргүй Чимэд гэж нэг өвгөн хүн байсан юм. Нэг ёсны одоо бол галч хүн юм даа, идээ боов чанадаг. Тэр араас нь шарсны овоотой байсан байгаа, чанадаг. Тэгээд л өнөө өвгөнийг гараад явахлээр зэрэг араас нь хулгай хийгээд л, боовыг нь хүүдийлээд л харьж байсан хүн дээ би. Тэгээд л түрэнхайхан боовыг нь зуураа хаячихдаг. Тэгээд муу Тайлаг Нанжид надтай цуг явж байсан юм ш дээ. Байсан юм, тэгэхэд хурал байсан юм. Бас л надад заалгасан, мэдүүлсэн юм байсан. Одоо тийм хүн ер нь энд байна уу, үгүй мэдэхгүй. Байхгүй байна.

Мөнхбат: Энэ Цагаан толгойн хурлын их лам нь ямар хүн байсан гэнэ ээ?

Мөнхтогоо: Энэ сав энэ хүн цухуйлгаж байна., Намсрай. Цэдэниш гэж хүнийг мэдэх үү, Цэдэниш тайж гэж тэр л энэ хуралд байсан хүн дээ.

Өсөхбаяр: Цагаан толгойн дуган чинь тоосгон дуган байсан уу, модон дуган байсан уу?

Мөнхтогоо: Дуган уу, мод.

Мөнхбат: Хэдэн дуган байсан юм, нэг дуган байсан уу?

Мөнхтогоо: Хоёр дуган байсан юм. Энэ чинь гурван дугантай байсан.

Өсөхбаяр: Хоёр дуган байсан гэхээр том суварга, хүрдний юм байсан уу?

Мөнхтогоо: Байсан байх аа, сайн мэдэхгүй.

Мөнхбат: Хэд орчим тооны лам байсан юм?

Мөнхтогоо: Би тэрнийг өнөө нөгөө, тэр чинь хэдэн он билээ. Галзуу нохойд уруулахад чинь, Дэндэв энэ тэр байсан юм болов уу...

Мөнхбат: Энэ Цагаан толгойн хурал хэд орчим ламтай байсан юм бол оо, энэ Нуураасаа бага байх даа?

Мөнхтогоо: Бага бага. Нуур чинь илүү. Лхамсүрэн гуай Цагаан толгойн хурлын гэсгүй, үнзад нь байсан юм. Одоо хотод байгаа.

Мөнхбат: Хотод тэр зүүн хүрээнд байгаа гэж яриад байгаа Лхамсүрэн гуай юу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхтогоо: Тийм байх аа.

Мөнхбат: Ер нь бол Лхамсүрэн гуай энэ Лүн сумын хүрээ хийдүүдийн түүхийг андахгүй мэдэх үү?

Мөнхтогоо: Андахгүй.

Мөнхбат: Өөрөө сууж байсан. Тэгэхээр бид нар Лхамсүрэн гуайтай уулзах нь зөв юм байна, тийм ээ?

Мөнхтогоо: Тийм, одоо энэ Даалин гэж уулыг тахиж байдаг юм ш дээ, манайхан чинь. Энэ Цагаан толгой чинь ойрхон. Их юм мэднэ ээ, бараг энд хурж байсан байх. Би тааруу мэднэ. Гэхдээ бас багцаатай юм мэднэ ээ.

Мөнхбат: Ямар ч гэсэн одоо лам нарын тоо, дуганы тоо, жас хөрөнгийн хувьд бол Цагаан толдгойн хурал Нуурын хурлаасаа арай бага?

Мөнхтогоо: Арай бага. Энэ Энлэгийн жас гэж хэлээд байгаа чинь аюултгүй байх шүү. Гэхдээ би нэг их очиж байгаагүй.

Мөнхбат: Энэ Долоотын хурлын тухай тэр Эрдэнэсант сумын номон дээр байна лээ л дээ, Чаван ламын хурал гэж?

Мөнхтогоо: Тийм, Чаван ламын хурал.

Мөнхбат: 40 гаруй, зарим үедээ 60 шахуу лам хурал хурдаг байсан гэж тэр номон дэр бичсэн байна лээ.

Мөнхтогоо: Аа тэрийг мэдэхгүй.

Мөнхбат: Тэр Чаван лам гэдэг ламыг та багадаа үзэж байв үү?

Мөнхтогоо: Үзсэн. Би намар жасаа хийж байхад нь очиж мөргөж байсан. Том лам шүү.

Мөнхбат: Долоотын хурал гэж яагаад нэрлэсэн юм бол, Долоот гэж газар ус тэнд байна уу?

Мөнхтогоо: Долоот гэж газар усны нэр.

Мөнхбат: Долоотын хурал хэдэн дугантай байсан юм бол оо?

Мөнхтогоо: Аа тэрийг мэдэхгүй.

Мөнхбат: Нэг жараад лам хурал хурдаг байсан гэхээр гурав, дөрвөн дугантай байсан юм байгаа биз, тийм ээ. Чаван лам гэж энэ нутгийн хүн үү?

Мөнхтогоо: Энэ нутгийн хүн. Том лам шүү, энэ хавийн хурлыг захирч байсан байх шүү.

Мөнхбат: Та тэр Долоотын хуралд сууж бас ном заалгаж байсан гэсэн тийм ээ?

Мөнхтогоо: Ном гэж надтай битгий ярь. Би тэр үед чинь бараг загнуулаад л хүзүүнээсээ чоголтой ном хүзүүлдээд л явж байсан хүн. Ном тогтоохгүй.

Мөнхбат: Ном тогтоодоггүй. Тэгээд л манз цав эргүүлээд л явж байх үү?

Мөнхтогоо: Аа манз цав эргүүлээд л. Лам нарын ард суучихсан, орой болохоор сож авна гээд л ноцолдчихдог. Гүйцэгддэггүй.

Мөнхбат: Сож гэдэг нь юу юм?

Мөнхтогоо: Сож гэдэг нь одоо бодохлээр тэр хурал номын барилга хэсгийн сахиж хонодог тийм хэсэг бүлэг байсан. Одоо жишээ нь нэг баг, бригад ч юм үү. Тэгээд л орой болоод лам нар тараад явахаар тоос манан хадчихдаг. Яаж байгаа юм, гэхлээр хучлага эргүүлээд л лам нарын жавдан дэвсрэг, олбогнуудыг хучиж унтах

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гээд. Тэгээд орой болохлээр тарна, тарахлээр зэрэг юу авах вэ гэхээр нэг тавтын улаан мөнгө ч юмуу. Нэг хөрөөдчихсэн жижиг цай хөлс нь юм даа, тэгж авдаг байсан юм. Тэгээд л нөгөө цайгийг чинь ижий, эмээдээ аваачиж өгнө. Өө юм олж ирсэн гээд л сайхан цай, жоохон дөрвөлжин цай. Тийм, манадаг нэг ёсондоо манаачирхуу л юм даа. Өө дандаа хүүхэд манана, 7, 8 хүүхэд. Тэгээд л би сахиус сахиж хононо гээд л үлдчихдэг.

Мөнхбат: Ямар сахиустай байсан юм бол оо?

Мөнхтогоо: Өө мэдэхгүй.